# ХЭНТИЙ АЙМГИЙН НИЙГМИЙН ДААТГАЛЫН ГАЗРЫН 2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт / хүрээгүй бол тайлбар / | Гүйцэтгэлийн хувь | Төсвийн ерөнхийлөн захирагчийн үнэлгээ |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 |
| ***Нэг. Бодлогын баримт бичигт тусгагдсан зорилт.*** | | | | | | | | |
| *“Нийгмийн даатгалын талаар төрөөс баримтлах бодлогын хэрэгжилтийг хангуулах, нийгмийн даатгалын төв, орон нутгийн нэгжийг мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, нийгмийн даатгалын сангийн орлого, зарлагын дунд хугацааны төсвийн төсөл, төсөөлөл болон төсвийн нарийвчилсан хуваарийн санал боловсруулах, гүйцэтгэлд хяналт тавих, судалгаа хийх, ирээдүйн төлөв байдал, урт хугацааны урьдчилсан тооцоолол хийх, үнэлэлт дүгнэлт өгөх, санал боловсруулах”* ***гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ:*** | | | | | | | | |
| 1.1.1. | Нийгмийн даатгалд хамрагдаагүй аж ахуйн нэгж, байгууллага, түүнд ажиллагчдыг шинээр хамруулах. | Үйл ажиллагааны зардлаар | Шинээр бүртгүүлсэн аж ахуйн нэгж, байгууллагын тоо, даатгуулагчдын тоо | 2023 онд 78 аж ахуйн нэгж, байгууллагын 283 даатгуулагч нийгмийн даатгалд шинээр хамруулсан. | Хэрэгжилтийг хангаж, хяналт тавьж ажиллах, үр дүнг тооцож Нийгмийн даатгалын ерөнхий газарт хүргүүлсэн байна. | 2024 оны байдлаар нийгмийн даатгалд шинээр 89 ажил олгогчийг нийгмийн даатгалд шинээр хамруулсан. Мөн албан журмын даатгуулагчийн тоог 296-аар нэмэгдүүлэн нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайланг хуулийн хугацаанд хүлээн авч баталгаажуулсан. | 100 | |
| 1.1.2. | Нийгмийн даатгалын сайн дураар даатгуулагчдын тоог 10-аас доошгүй хувиар нэмэгдүүлэх, малчдын нийгмийн даатгалын хамрагдалтыг 30-аас доошгүй хувьд хүргэх, хөдөлмөрийн гэрээ бүхий туслах малчныг бүрэн хамруулах. | Үйл ажиллагааны зардлаар | 2023 онд нийт 4328 сайн дурын даатгуулагч хамрагдсанаас 2813 нь . малчин даатгуулагч. | | Хэрэгжилтийг хангаж, хяналт тавьж ажиллах, үр дүнг тооцож Нийгмийн даатгалын ерөнхий газарт хүргүүлсэн байна. | Тайлант хугацаанд Нийгмийн даатгалын байгууллагатай шинээр гэрээ байгуулсан, сунгасан 4969 иргэн сайн дурын даатгалын шимтгэлийг төлсөн байна.<br>Үүнээс 835 даатгуулагч сайн дурын даатгалд шинээр хамрагдсан.<br>Мөн сайн дурын даатгалд хамрагдсан малчдын тоо нийт 2286 байгаа бөгөөд энэ онд шинээр 486 малчин, 0-3 хүртэлх насны хүүхдээ асарч байгаа эхийн даатгалд нийт 876 даатгуулагч шимтгэл төлснөөс шинээр 63 даатгуулагч эх, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдээ асарч байгаа эцэг, эхийн | 91 | |

<table>
<tr><td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td><td>даатгалд энэ онд шинээр 102 даатгуулагч тус тус хамрагдсан байна.</td><td></td><td></td></tr>
<tr><td>1.1.3.</td><td>Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2024 оны 01 дүгээр сарын 04-ний өдрийн А/02 тоот “2024 оны төсвийн хуваарь батлах тухай” тушаалын хэрэгжилтийг хангаж ажиллах</td><td>Шаардлагагүй</td><td>2024 оны Нийгмийн даатгалын сангийн орлого, зарлагын гүйцэтгэл хувиар</td><td>2022 оны Нийгмийн даатгалын сангийн орлого 100, зарлагын гйүцэтгэл 90 хувьтай биелсэн</td><td>Шинэчлэгдэн батлагдсан төсвийн хүрээнд хяналт тавьж ажилласан байна.</td><td>Тус газар нь 2024 оны санхүүгийн жилд сангийн орлого 58,793.56 сая төгрөг, зарлагын гүйцэтгэл 126,253.62 сая төгрөгөөр тус тус батлагдсан. Тайлант хугацаанд орлогын төлөвлөгөө 58,793.56 сая төгрөг, зарлагын гүйцэтгэл 126,253.62 сая төгрөг буюу 100 хувиар тус тус биелсэн байна.</td><td>100</td><td></td></tr>
<tr><td colspan="9">Биелэлт – 291/3 97 %</td></tr>
<tr><td colspan="8">Хоёр. Хуулиар тусгайлан олгосон чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт</td><td></td></tr>
<tr><td colspan="8">“Нийгмийн даатгалын сангийн орлого бүрдүүлэх, тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, зардлыг хугацаанд нь олгох, өр, авлага барагдуулах ажлыг удирдан зохион байгуулах, өмчийн харилцаа, хөрөнгө оруулалтын үйл ажиллагааг зохион байгуулах, нийгмийн даатгалын сангийн хуримтлал бий болгох, нягтлан бодох бүртгэлийн мэргэжил арга зүйгээр хангах, гүйцэтгэлийг тайлагнах” гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ:</td><td></td></tr>
<tr><td>2.1.1.</td><td>Нийгмийн даатгалын сангийн шимтгэлийн орлогын төлөвлөгөөг жигд хангаж биелүүлэх.</td><td></td><td>Сар бүр 100 Хувиар</td><td>Нийгмийн даатгалын сангийн орлогын төлөвлөгөөг сар, улирал, жилээр жигд хангаж биелүүлж, нийгмийн дааталын сангийн орлогыг 49524.6 сая төгрөгөөр буюу 104 хувиар биелүүлсэн.</td><td>Нийгмийн даатгалын сангийн орлогын төлөвлөгөөг сар, улирал, жилээр жигд хангаж биелүүлж, нийгмийн дааталын сангийн орлогыг 53465,4 сая төгрөг буюу 100 хувь биелүүлсэн байх.</td><td>Нийгмийн даатгалын сангийн орлогын төлөвлөгөөг 83.2-100 хувиар 1-12 дугаар саруудад биелүүлэн ажилласан, бүтэн жилийн байдлаар 58,793,56 сая төгрөгийн орлого хуримтлуулсан.
<table>
<tr><th>Сар</th><th>Төлөвлөгөө</th><th>Гүйцэтгэл</th><th>хувь</th></tr>
<tr><td>1</td><td>3,552,27</td><td>2,958,23</td><td>83.2</td></tr>
<tr><td>2</td><td>7,289,61</td><td>6,530,37</td><td>90.0</td></tr>
<tr><td>3</td><td>12,073,28</td><td>11,519,66</td><td>95.4</td></tr>
<tr><td>4</td><td>16,150,71</td><td>16,035,00</td><td>99.3</td></tr>
<tr><td>5</td><td>20,609,13</td><td>20,731,18</td><td>101.0</td></tr>
<tr><td>6</td><td>25,745,61</td><td>25,838,60</td><td>100.4</td></tr>
<tr><td>7</td><td>29,541,79</td><td>31,827,37</td><td>107.7</td></tr>
<tr><td>8</td><td>33,887,36</td><td>35,740,53</td><td>105.4</td></tr>
<tr><td>9</td><td>38,612,44</td><td>40,825,30</td><td>105.7</td></tr>
<tr><td>10</td><td>43,145,94</td><td>46,359,55</td><td>107.4</td></tr>
<tr><td>11</td><td>47,811,01</td><td>51,183,70</td><td>107.0</td></tr>
<tr><td>12</td><td>58,793,56</td><td>58,793,56</td><td>100.0</td></tr>
</table></td><td>100</td><td></td></tr>
</table>

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 2.1.2. | Ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэлийн авлагыг бууруулах талаар нэгдсэн арга хэмжээ зохион байгуулж оны эхний үлдэгдлээс бууруулах, үр дүнг тооцож газрын даргын зөвлөлийн хурлаар хэлэлцэж, тайланг НДЕГ-т хүргүүлэх. | | Ажил олгогчийн шимтгэлийн авлагыг 60-с доошгүй хувиар бууруулна | Нийгмийн даатгалын сангийн шимтгэлийн орлогод эзлэх авлагын хэмжээг 4 хувьтай гарсан | а) Нийгмийн даатгалын сангийн шимтгэлийн орлогод эзлэх авлагын хэмжээг 10.0 хувиас хэтрүүлэхгүй байх<br>б) Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албанд шилжсэн шимтгэлийн авлагыг бүрэн барагдуулах. | а) 2023 оны жилийн эцсээр нийт 2,980,7 сая төгрөгийн авлагатай гарснаас тайлант хугацаанд нийт авлагын 94.3% буюу 2,813,6 сая төгрөгийг барагдуулсан байна. Урсгал авлага өсгөөгүй.<br>б) Шүүхийн шийдвэр гүйцэтгэлийн албанд нийт 12 аж ахуй нэгжийн 118.6 сая төгрөгийн найдваргүй авлагыг шилжүүлж, 112,1 сая төгрөгийг барагдуулсан. Данс хаасан 174 аж ахуй нэгжийн 1158,5 сая төгрөгийн авлагаас 1100,1 сая төгрөг, Хэнтий аймаг дахь Сум дундын иргэний хэргийн анхан шатны шүүхэд 12 аж ахуй нэгжийн 88.6 сая төгрөгийн авлага барагдуулах арга хэмжээ авсан байна. | 95 | |
| 2.1.3. | Ажил олгогчоос бусад даатгуулагчийн нийгмийн даатгалын шимтгэлийн тооцооны үлдэгдлийг барагдуулах | | Ажил олгогчоос бусад даатгуулагчийн нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын шимтгэлийн тооцооны үлдэгдэлгүй гарсан эсэх | Сайн дурын даатгуулагчийн шимтгэлийн тооцоог бүрэн хийсэн. | а) Сайн дурын даатгуулагч, малчин болон бусад даатгуулагчийн шимтгэлийн тооцоог тухай бүр хийж, тооцооны үлдэгдэлгүй байх. | Нийгмийн даатгалын сангийн нягтлан бодох бүртгэлийг “Core” системээр хөтлөн, ажлын гүйцэтгэлийг хангаж тухай бүр орлого таниулдаг. Танигдсан орлого системээс автоматаар ногдуулалт хийгдэж авлага хаагддаг ба ногдуулалт хийгдээгүй үүссэн төлөвтэй шимтгэлийн орлогыг сайн дурын байцаагч, сангийн нягтлан бодогч нар тулгаж шинээр гэрээ байгуулах, сунгах ажлыг хийж гүйцэтгэсэн ба сайн дурын даатгуулагчийн тайлан нь тооцооны үлдэгдэлгүй гарсан. | 100 | |
| 2.1.4. | Ажил олгогч, даатгуулагчийн шимтгэлийн тооцооноос бусад өглөг, авлагыг барагдуулах | | Ажил олгогч, даатгуулагчийн шимтгэлийн тооцооноос бусад өглөг, авлагыг хугацаанд нь бүрэн барагдуулсан эсэх. | а) Нийгмийн даатгалын сангийн бусад өр, авалагын тооцоог хийсэн<br>б) Нийгмийн даатгалын байгууллагын өр, авалагын тооцоог хийсэн. | а) Нийгмийн даатгалын сангийн бусад өр, авлагыг барагдуулах.<br>б) Нийгмийн даатгалын байгууллагын бусад өр, авлагыг барагдуулах. | а/ Нийгмийн даатгалын сангийн бусад өр, авлагыг барагдуулах ажлын хүрээнд сум тус бүр өглөг авлагын тайланг хүргүүлэн барагдуулж ажилласан. Бусад өглөг, авлаг нь ихэвчлэн сангийн данс хооронд андууран хийсэн гүйлгээ байдаг бөгөөд тайлант онд бусад өглөг 11,5 сая, авлага 54,3 саяын үлдэгдэлтэй гарсан ба бусад өглөг оны эхний үлдэгдлээс 45,5 хувиар, авлага 10 хувиар тус тус буурсан байна.<br>б) Нийгмийн даатгалын байгууллагын үйл ажиллагаа оны эхэнд өглөг, авлагагүй гарсан бөгөөд 2024 оны жилийн эцсийн байдлаар өглөг авлага | 70 | |

<table>
<tr><td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td><td>үүсгээгүй ажилласан болно.</td><td></td><td></td></tr>
<tr><td>2.1.5.</td><td>Нийгмийн даатгалын сангийн орлогыг төв санд төвлөрүүлэх.</td><td></td><td>Нийгмийн даатгалын сангийн төвлөрүүлэлтийг хугацаанд нь бүрэн төвлөрүүлсэн эсэх.</td><td>Нийгмийн даатгалын сангийн орлогыг төв санд бүрэн төвлөрүүлсэн.</td><td>Нийгмийн даатгалын сангийн орлогыг төв санд өдөр бүр төвлөрүүлэх.</td><td>НДЕГ-ын даргын 2023 оны А/183 дугаартай тушаалын дагуу нийгмийн даатгалын сангийн орлогыг өдөр бүр ерөнхий газрын төв санд төвлөрүүлэн ажилладаг.<br>2024 оны санхүүгийн жилд 58,793.56 сая төгрөгийн орлогыг төв санд төвлөрүүлсэн байна.</td><td>100</td><td></td></tr>
<tr><td>2.1.6.</td><td>Нийгмийн даатгалын сангийн зардлыг батлагдсан төлөвлөгөөний дагуу зарцуулах.</td><td>124675,6 сая төг</td><td>Хууль тогтоомжийн дагуу иргэд даатгуулагчдад тэтгэвэр тэтгэмжийн үйлчилгээг тогтоосон хугацаанд үзүүлсэн байна.</td><td>Нийгмийн даатгалын сангийн зардлыг батлагдсан төлөвлөгөөний дагуу зарцуулсан.</td><td>а) Тэтгэврийг сар бүрийн 01-ний өдөр олгох<br>б) Нийгмийн даатгалын сангийн зардлыг батлагдсан төлөвлөгөөний дагуу зарцуулах.</td><td>а/ Арилжааны банктай хамтран ажиллах гэрээний дагуу ХААН, Төрийн банканд тэтгэврийн файлыг сар бүрийн ажлын сүүлийн өдрийн 10 цагаас өмнө хүргэж сар бүрийн эхэн буюу 01-нд тэтгэврийг олгож хэвшсэн боловч нийгмийн даатгалын системийн нэгдсэн шинэчлэлтэй холбоотойгоор зарим даатгуулагчдын тэтгэврийг жагсаалт хэлбэрээр банканд хүргүүлж олгосон.<br>б/ Нийгмийн даатгалын сангийн зардлыг батлагдсан төлөвлөгөөний дагуу сан тус бүрээр зориулалтын дагуу зарцуулсан.<br>Сангийн зарцуулалт / сая төг/
<table>
<tr><td>Сан</td><td>Төлөвлөгөө</td><td>Гүйцэтгэл</td><td>хувь</td></tr>
<tr><td>Тэтгэвэр</td><td>113918,7</td><td>113918,7</td><td>100</td></tr>
<tr><td>Тэтгэмж</td><td>5348,1</td><td>5348,1</td><td>100</td></tr>
<tr><td>ҮОМШӨ</td><td>5446,5</td><td>5446,5</td><td>100</td></tr>
<tr><td>Ажилгүйдэл</td><td>1530,2</td><td>1530,2</td><td>100</td></tr>
<tr><td>нийт</td><td>126243,5</td><td>126243,5</td><td>100</td></tr>
</table></td><td>100</td><td></td></tr>
<tr><td>2.1.7.</td><td>Үйл ажиллагааны батлагдсан зардлын төсөв, хөрөнгө оруулалтын зардлын үр ашгийг дээшлүүлж, хэмнэлтийн зарчмыг баримтлах, төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний</td><td>1493,4 сая төгрөг</td><td>а)Батлагдсан төсвийг зардлын эдийн засгийн ангилал хооронд шилжүүлэн зарцуулсан эсэх,<br>б)Ажиллагсадт</td><td>Батлагдсан 1288779.7 төсвийг зардлын ангиллын дагуу зарцуулан ажиллаж өглөг, авлага үүсгээгүй.</td><td>а) Батлагдсан төсвийг зардлын ангиллын дагуу зарцуулах<br>б) Ажиллагсадтай холбоотой цалин, шимтгэл, татвар болон бусад өр авлага үүсгэхгүй байх.<br>в) Төсвийн хэмнэлтийн бодлогыг хэрэгжүүлэх.</td><td>а) Байгууллагын үйл ажиллагааны зардалд 1,548.82 сая төгрөг батлагдсанаас цалин хөлсөнд 1,103.15 сая төгрөг НДШ-д 139.40 сая төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардалд 43.46 сая төгрөг, хангамж бараа материалын зардалд 16.84 сая төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардалд 5.89 сая төгрөгийг, эдийн</td><td></td><td></td></tr>
</table>

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад хяналт тавих | | ай холбоотой болон бусад өр авлагагүй ажилласан эсэх,<br>в)Улсын Их хурлын 2016 оны 47 дугаар тогтоолийн хэрэгжилтийн хангасан эсэх, | | | засгийн ангилал зориулалтын дагуу батлагдсан төсвийн хүрээнд зарцуулж, хүний нөөцийн дутмагтай холбоотой цалин сан хэмнэгдсэн.<br>б) Тайлант хугацаанд албан хаагчидтай холбоотой цалин болон нийгмийн даатгалын шимтгэл, ХХОА татварыг тухай бүр шилжүүлж өглөг авлага үүсгэлгүй ажилласан болно.<br>в) Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэн зардал тус бүрийг хэтрүүлэлгүй зарцуулж, батлагдсан төсөвтөө багтаан ажил үйлчилгээг явуулсан ба батлагдсан 45 орон тооноос 39 орон тоотой ажиллаж байна. | 100 | |
| 2.1.8. | Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах, нийгмийн даатгалын сангийн анхан болон нягтлан бодох бүртгэл хөтлөх, төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, санхүүгийн тайлан гаргах ажлыг зохион байгуулах. | | Санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайланг үнэн зөв гаргаж, тогтоосон хугацаанд ирүүлсэн эсэх | Нийгмийн даатгалын сангийн санхүүгийн тайлан болон нэгдсэн санхүүгийн тайлан, Plastic” програмаар хөрвүүлсэн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлан, байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлан, сангийн орлого, зарлагын төсвийн гүйцэтгэлийн мэдээ, байгууллагын төсвийн гүйцэтгэлийн зарлагын мэдээ, сангийн өр авлага, хамралтын сарын мэдээг гаргаж, ирүүлсэн. | Нийгмийн даатгалын сангийн санхүүгийн тайлан болон нэгдсэн санхүүгийн тайлан, сангийн орлого, зарлагын төсвийн гүйцэтгэлийн мэдээ, байгууллагын төсвийн гүйцэтгэлийн зарлагын мэдээ, сангийн өр авлага, хамралтын сарын мэдээг үнэн зөв гаргаж, хугацаанд нь ирүүлэх. | Нийгмийн даатгалын сангийн анхан шатны баримт материалыг үндэслэн ажил гүйлгээг нягтлан бодох бүртгэлд үнэн зөв тусгаж, санхүүгийн тайланг цаг хугацаанд нь гаргасан.<br>Нийгмийн даатгалын сангийн орлого, зарлагын төсвийн гүйцэтгэлийн 1-11 сарын мэдээг сар бүрийн 02-ны дотор НДЕГазарт цахимаар илгээсэн.<br>Мөн дараах мэдээ тайланг хугацаанд нь гаргаж хүргүүлсэн байна.<br>-Сарын мэдээ- 11 удаа<br>-Нийгмийн даатгалын сангийн өр, авлагын мэдээ- 11 удаа<br>-Байгууллагын төсвийн гүйцэтгэлийн мэдээ -11 удаа<br>-Нийгмийн даатгалын сангийн санхүүгийн тайлан – 2 удаа<br>- Байгууллагын санхүүгийн тайлан - 2 удаа<br>-Сангийн төсвийн гүйцэтгэлийн тайлан- 2 удаа<br>Э-тайлан - 2 удаа тус тус НДЕГазраас ирүүлсэн хуваарийн дагуу хугацаанд нь чанартай гаргаж цахимаар болон цаасаар хүргүүлэн ажилласан. | 100 | |
| 2.1.9. | Байгууллагын хэвийн үйл ажиллагаанд шаардагдах өмч хөрөнгийн хэрэгцээ, | | Байгууллагын хэвийн үйл ажиллагаанд шаардагдах | Байгууллагын хэвийн үйл ажиллагаанд шаардагдах өмч | -Үндсэн хөрөнгө актлах, шилжүүлэх үйл ажиллагааг хууль дүрэм, журамд нийцүүлэн өмч | Нийгмийн даатгалын газар нь үндсэн хөрөнгийн тооллогыг байгууллагын даргын тушаалаар комисс томилон хагас, бүтэн жилээр тооллогын ажлыг | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | захиран зарцуулалт, хадгалалт хамгаалалтыг төлөвлөх, хэрэгжүүлэх, ил тод тайлагнах. | | өмч хөрөнгийн хэрэгцээ, захиран зарцуулалт, хадгалалт хамгаалалтыг төлөвлөн хэрэгжүүлж, тайлагнасан эсэх | хөрөнгийн хэрэгцээ, захиран зарцуулалт, хадгалалт хамгаалалтыг төлөвлөн хэрэгжүүлж, тайлагнасан байна. | хамгаалах байнгын зөвлөлийн дүгнэлт, холбогдох баримтыг үндэслэн хөрөнгийн нэмэгдэх, хасагдах хөдлөлийг цаг тухай бүрд нь бүртгэлд тусгах.<br>-Эзэмшил газар, барилга байгууламж, тээврийн хэрэгсэл, үндсэн хөрөнгө г.м/ нэгдсэн судалгааны маягтууд ТӨХ /ТӨХ-1-с ТӨХ-11 маягт/ болон мэргэжлийн байгууллагад гаргаж өгдөг мэдээ тайланг хуулийн хугацаанд мэдээлэх.<br>-Хөрөнгийн ашиглалт хадгалалт, хамгаалалтад хяналт тавьж, үндсэн хөрөнгө, маягтын тооллого хийх ажлыг зохион байгуулж, дүнг хугацаанд нь иргүүлэх .<br>-Өмч хамгаалах байнгын зөвлөл журмын дагуу ажиллуулах.<br>-Үндсэн хөрөнгийн хөдлөл, өөрчлөлтийн тайланг “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем” програмд дараа оны 3 дугаар сарын 5-ны дотор оруулах.<br>-Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн гэрээ, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг бүрэн хангах, Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн гэрээний орлогыг санд бүрэн төвлөрүүлэх. | хийдэг.Тооллогоор бүх байцаагч, ажилчдын ашиглаж буй өмч хөрөнгөд хяналтын тооллого хийж, тэдгээрийн эд хөрөнгийг ашиглалтын карттай тулгалт хийн баталгаажуулдаг.<br>2024 оны хагас жилийн тооллогыг 07 дугаар сард хийж холбогдох тайланг гарган тооцоо хийсэн.Жилийн эцсийн байдлаарх үндсэн хөрөнгийн тооллогын бэлтгэл ажил хийгдэж байна<br>Тус газрын эзэмшил газар, барилга, байгууламж, тээврийн хэрэгсэл, үндсэн хөрөнгийн судалгааг маягтын дагуу гарган Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын burtgel.pcsp.gov.mn хуудсанд хугацаанд нь байршуулсан.<br>Тус газрын өмч хамгаалах байнгын зөвлөл нь тайлант хугацаанд 1 удаа хуралдаж үндсэн хөрөнгийн элэгдлээ бүрэн нөхсөн, цаашид ашиглах боломжтой хөрөнгийг дахин үнэлэх болон цаашид ашиглах боломжгүй, өртгөө бүрэн нөхсөн хөрөнгийг актлах саналыг хэлэлцэн Нийгмийн даатгалын ерөнхий газарт хүргүүлсэн.<br>Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газраас 2023 оны хийсэн ажлын гэрээ дүгнэж тус газар нь 94 хувьтай дүгнүүлсэн.<br>Түрээсийн гэрээ байгуулж ажилладаггүй болно. | 100 | |
| | Төсвийн тухай хууль тогтоомжийн | | Зөрчилгүй дүгнэлт авч, | а) Нийгмийн даатгалын сангийн | а) Нийгмийн даатгалын сангийн санхүүгийн | а/ Тус газар нь 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 2.1.10. | хэрэгжилтийг хангуулах ажлыг зохион байгуулж, жилийн эцсийн тайланд аудитын байгууллагаас зөрчилгүй дүгнэлт авах. | | зөвлөмж, акт, албан шаардлагыг хугацаанд нь бүрэн биелүүлсэн эсэх | санхүүгийн тайлангийн аудитын шалгалтаар зөрчилгүй дүгнэлт авсан.<br>б) Санхүүгийн тайлангийн аудитын тайлангаар өгсөн залруулга, зөвлөмж, акт, албан шаардлагыг хэрэгжүүлсэн. | тайлангийн аудитын шалгалтаар зөрчилгүй дүгнэлт авах.<br>б) Санхүүгийн тайлангийн аудитын тайлангаар өгсөн залруулга, зөвлөмж, акт, албан шаардлагыг 100.0 хувь биелүүлэх. | байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам заврын дагуу үнэн бодитой, шударга илэрхийлсэн тул аймгийн Аудитын газраас **ЗӨРЧИЛГҮЙ** дүгнэлт авсан болно.<br>б/ Аудитын явцад үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй бүртгэлд үлдэгдлийг 1.5 сая төгрөгөөр илүү илэрхийлсэн алдааг залруулсан. Мөн аудитаар нийт 26.0 сая төгрөгийн албан шаардлага, 0.3 сая төгрөгийн актын төлбөр зөрчил илэрснийг 100 хувь биелэлттэй Хэнтий аймаг дахь Төрийн Аудитын газарт хугацаанд нь хүргүүлсэн. | 100 | |
| 2.1.11. | Нийгмийн даатгалын сангийн цахим мэдээллийн санг цаг тухай бүр үнэн зөв бүрдүүлэх. | | Байцаагч ажилтнуудын хариуцлага өсч, мэдээллийн сангийн мэдээлэл үнэн зөв баталгаатай бүртгэгдсэн эсэх | Нийгмийн даатгалын сангийн мэдээллийн баазыг тогтоосон хугацаанд хаалт хийлгэсэн. | а) Анхан шатны болон нягтлан бодох бүртгэлийг цаг хугацаанд нь үнэн зөв бүртгэх ажлыг зохион байгуулж, бүртгэлийн алдаа, залруулга гаргахгүй байх.<br><br>б) Нийгмийн даатгалын сангийн мэдээллийн баазыг тогтоосон хугацаанд хаалт хийлгэх ажлыг зохион байгуулах. | а/ Нийгмийн даатгалын сангийн анхан шатны баримт материалыг үндэслэн ажил гүйлгээг бүртгэлд үнэн зөв тусгаж, санхүүгийн тайланг цаг хугацаанд нь гаргах ажлыг зохион байгуулан ажилласан.<br>Шинээр хамрагдсан **89** аж ахуйн нэгжийн материалыг улсын бүртгэлийн баазтай тулгаж мэдээллийн баазад үнэн зөв бүртгэсэн. Үйл ажиллагаа нь зогссон **17** аж ахуйн нэгжийн хөдөлгөөнийг мэдээллийн баазад оруулж идэвхгүй төлөвт шилжүүлсэн.<br>б/ 2023 оны эцсийн үйлчилгээ буюу нийгмийн даатгалын сангийн мэдээллийн баазыг хуваарийн дагуу татуулж хөрвүүлэн, тохируулга үйлчилгээг бүрэн хийлгэж баталгаажуулсан. Оны үйлчилгээний журмын хэрэгжилтийг Санхүү бүртгэл хамралт, орлогын хэлтсийн дарга бөгөөд ахлах нягтлан бодогч А.Эрдэнэчимэг мэдээллийн технологийн мэргэжилтэн Б.Баярсайхан нар бэлэн байдлыг ханган ажилласан. | 100 | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| 2.1.12. | Нягтлан бодох бүртгэлийн тооцооны өглөг, авлагыг тооцоо нийлсэн актаар шинэчлэн баталгаажуулах | | Нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомжийг хэрэгжүүлсэн эсэх | Тооцооны үлдэгдлийг баталгаажуулсан. | а) Нийгмийн даатгалын байгууллагын санхүүгийн тайлангийн тооцооны үлдэгдлийг эзэн холбогдогч бүрээр бүрэн шинэчлэн баталгаажуулах. б) Нийгмийн даатгалын сангийн санхүүгийн тайлангийн тооцооны үлдэгдлийг эзэн холбогдогч бүрээр бүрэн шинэчлэн баталгаажуулах. | а/ Нийгмийн даатгалын байгууллагын үйл ажиллагааны санхүүгийн тайлангаар өглөг авлага гараагүй бөгөөд харилцагч байгууллагуудтай өр авлагагүй гэсэн тооцоо нийлсэн актыг улирал бүр нийлж баталгаажуулан ажиллаж хэвшсэн. б/ Нийгмийн даатгалын сангийн санхүүгийн тайлангаар гарсан өглөг, авлагын үлдэгдлийг хариуцсан байцаагч, байгууллагатай улирал бүр баталгаажуулан ажиллаж хэвшсэн. | 100 | |
| ***Биелэлт – 1165/12 97,08 %*** | | | | | | | | |
| ***Гурав. Хуулиар олгосон нийтлэг чиг үүргийг хэрэгжүүлэх зорилт*** | | | | | | | | |
| *“Нийгмийн даатгалын бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн биелэлт, үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийх, сангийн болон үйл ажиллагааны зардлын зарцуулалтад аудит хийх, дүгнэлт зөвлөмж гаргах, мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх”* ***гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ:*** | | | | | | | | |
| 3.1.1. | Нийгмийн даатгалын сан болон үйл ажиллагааны хэрэгжилтэнд дээрээс ирсэн чиглэлийн дагуу дотоод аудит хийх; | | Батлагдсан удирдамжийн дагуу дотоод үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж, шалгалтын үр дүнг газрын даргын зөвлөлийн хурлаар танилцуулж, баталгаажуулан тайланг Дотоод аудит, мониторингийн газарт хүргүүлсэн байна. | | Батлагдсан удирдамжийн дагуу дотоод үйл ажиллагаанд хяналт шалгалт хийж дүнг хэлэлцүүлэн тайлганасан байна. | Захиргаа хяналтын хэлтэс нь 2024 онд хийх хяналт, шалгалтын төлөвлөгөөг газрын даргаар батлуулан нийгмийн даатгалын тухай хууль түүнд нийцүүлэн гаргасан журам, заавар чиглэлийн дагуу дотоодын хяналт шалгалтын ажлыг зохион байгуулан ажиллаж байна. Хяналт шалгалтын төлөвлөгөөний дагуу нийгмийн даатгалын газрын архивд хүлээлгэн өгсөн 2023 оны үйл ажиллагааны болон нийгмийн даатгалын сангийн баримтын бүрдлийг холбогдох журмын дагуу шалган хүлээлгэн өгсөн. Шалгалтаар 4 сумын 15 боть баримтын бүрдлийг хангуулахаар хугацаатай үүрэг даалгавар өгч буцаасныг залруулан авсан. НДЕГ-ын даргын 2024 оны 05 дугаар сарын 29-ний өдрийн дотоодын хяналт сайжруулах 01/1107 тоот албан бичгийн дагуу шинээр нэвтрүүлсэн SICOS системд тэтгэвэр, тэтгэмжийн тогтоолт, олголт, өөрчлөлт, шилжилт хөдөлгөөнийг оруулахад алдаа гарсан, илүү дутуу олгосон эсэхэд хяналт шалгалтыг зохион байгуулсан. Уг шалгалтаар 14664 тэтгэвэр, тэтгэмж авагчийн | 100 | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | тогтоолт, олголтыг хянан үзэж 169 даатгуулагчтай холбоотой 39.9 сая төгрөгийн зөрчил илрүүлэн барагдуулсан байна. | | |
| 3.1.2. | Шилэн дансны тухай хуулийг хэрэгжилтэд аудит хийх; | | Шилэн дансны тухай хууль, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ыг баримталсан байна. | 2023.01.01-2023.11.30-ны хүртэлх хугацааны Шилэн дансны хуулийн хэрэгжилтэд аудит хийсэн. | Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт хангагдаж, мэдээллийг үнэн зөв, хуулийн хугацаанд байршуулсан байна. | Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2023 оны 12 дугаар сарын 26-ны өдөр баталсан Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд дотоод аудит хийх удирдамжийн дагуу Хэнтий аймгийн Нийгмийн даатгалын хэлтэс нь 2024 оны 01 дүгээр сарын 03-05-ны өдрийн хооронд дотоод аудитын ажлыг зохион байгуулсан. Уг ажлын хүрээнд шилэн дансны тухай хууль тогтоомжийн хэрэгжилт, шилэн дансны цахим хуудасны 2023 оны хөтлөлт, тайлан мэдээ байршуулсан байдал, холбогдох шийдвэрийн хуулбар, баримт бичгийг оруулсан эсэхэд үнэлгээ өгч, гарсан зөрчлийг давтан гаргахгүй байх чиглэл өгч ажилласан. Шилэн дансны мэдээллийг цахим системд тухай бүр, хуулийн хугацаанд тайлагнаж байгаа бөгөөд байгууллагын үйл ажиллагаатай холбоотой 139 мэдээлэл байршуулахаас хугацаандаа мэдээлснээс 138, хугацаа хоцорч мэдээлснээс 1 мэдээ байна. Нийгмийн даатгалын сантай холбоотой 130 мэдээлэл байршуулахаас хугацаандаа мэдээлснээс 124, хугацаа хоцорч мэдээлснээс 6 мэдээ байна. Энэ нь 1-дүгээр улирлаар 2 мэдээлэл буруу оруулснаас болж засварлах үйлдэл хийсэн тул хугацаа хоцорсон байна. Мөн 3 дугаар улирлын байдлаар хугацаа хоцроосон мэдээлэл байхгүй боловч нийгмийн даатгалын сангийн 5 саяас дээш дүнтэй орлого, зарлагын гүйлгээг дутуу оруулсан зөрчил гарсныг тухай бүр залруулан ажилласан. 2024 онд НДЕГ-аас ирүүлсэн чиглэл, “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын дагуу шилэн дансны тухай | 90 | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хуулийн хэрэгжилт, мэдээллийн үнэн зөв, бүрэн байршуулсан эсэхэд улирал бүр хяналт тавих ажлыг Санхүү бүртгэл, хамралт, орлогын хэлтэстэй хамтран хийж гүйцэтгэж байна. | | |
| 3.1.3. | Дотооддоо сургалт зохион байгуулах; | | Зохион байгуулсан сургалт, арга хэмжээний тоо /Жилд 4-өөс доошгүй/ | Албан хаагчдыг мэргэшүүлэх, ур чадварыг дээшлүүлэх 4 удаагийн сургалтад 35 албан хаагчийг хамруулсан. | Нийгмийн даатгалын тухай хууль болон холбогдох бусад хууль, тогтоомжийн мэдлэг дээшилсэн байна. | Тус газар нь Нийгмийн даатгалын тухай хуулийн хэрэгжилт, түүнд нийцүүлэн гаргасан гарсан бусад эрх зүйн акт, хуульд орсон өөрчлөлт, түүнийг нэг мөр болгон ойлгох, газрын болон сумдын байцаагч, албан хаагчдын сургалтыг цахим хэлбэрээр 2024 оны тайлант хугацаанд 44 удаа зохион байгуулж давхардсан тоогоор 840 байцаагч, албан хаагчийг хамруулсан. | 100 | |
| *“Нийгмийн даатгалын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг ажил олгогч, даатгуулагч, иргэн болон нийгмийн даатгалын орон нутгийн нэгжид хяналт шалгалт хийж шийдвэр гаргах, мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх, соён гэгээрүүлэх, урьдчилан сэргийлэх, үр дүнг сайжруулах чиглэлээр санал боловсруулах”* ***гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ:*** | | | | | | | | |
| 3.2.1 | Нийгмийн даатгалын тухай хуулийн хэрэгжилтийг дээд газраас өгсөн чиглэлийн дагуу болон газрын даргын баталсан удирдамжийн дагуу гадаад болон дотоодын хяналт шалгалтыг зохион байгуулах. | | Холбогдох хууль тогтоомж, дүрэм, журмын хэрэгжилтийг шалгаж, илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах арга хэмжээ авах, | Шалгалт хийж илэрсэн зөрчлийг арилгах, | Шалгалтын үр дүнг улирал тутамд тооцон газрын даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж холбогдох шийдвэр гаргуулан актаар тогтоогдсон төлбөрийн 70-аас доошгүй хувийг барагдуулсан байна. | Захиргаа хяналтын хэлтсийн 2024 онд хийх хяналт, шалгалтын төлөвлөгөөг газрын даргаар батлуулан, нийгмийн даатгалын тухай хууль түүнд нийцүүлэн гаргасан журам, заавар чиглэлийн дагуу дотоодын хяналт шалгалтын ажлыг зохион байгуулсан.<br>Монгол Улсын Засгийн газрын 2023 оны 420 дугаар тогтоолоор баталсан "Салбарын хяналт шалгалтын 2024 оны төлөвлөгөө"-ний дагуу Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Салбарын хяналтын газрын даргын баталсан 2024 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн 13-07/08 дугаартай "Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын санд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх тухай удирдамжийн хүрээнд 2024 оны 04 дүгээр сарын 15-19-ний өдрүүдэд Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сангийн 2021- 2023 оны орлого бүрдүүлэлт, зарцуулалтын хэрэгжилтийг шалгасан. Шалгалтаар 107.3 сая төгрөгийн улсын байцаагчийн акт үйлдэн, 74.1 сая | 100 | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | төгрөгийг барагдуулан, 33.2 сая төгрөгийн төлбөр зөрчлийг арилгуулах ажлыг зохион байгуулан ажиллаж байна.<br>Хэнтий аймгийн Нийгмийн даатгалын газрын 2024 оны хяналт шалгалтын төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу Дархан, Баянмөнх сумын төсөвт байгууллагуудын 2022-2023 оны санхүү, нягтлан бодох бүртгэлийн баримтад хяналт шалгалтын ажлыг зохион байгуулсан. Шалгалтаар давхардсан тоогоор 93 даатгуулагчийн 50.4 сая төгрөгийн цалин хөлс, түүнтэй адилтгах орлогод 11.9 сая төгрөгийн шимтгэл ногдуулан хугацаа хэтрүүлсэн хоногт 5.9 сая төгрөгийн алданги тооцон улсын байцаагчийн акт үйлдэн нийт 17.8 сая төгрөгийг нөхөн төлүүлэхээр шийдвэрлэсэн. Мөн 10 байгууллагын албан тоот, хүсэлтийн дагуу улсын байцаагчийн акт үйлдэн нийт 0.87 сая төгрөгийн төлбөр, зөрчил илрүүлснийг төлүүлэхээр шийдвэрлэсэн.<br>Дотоодын хяналт шалгалтын явцад илэрсэн өндөр насны 2 тэтгэвэр авагчийн 7.2 сая төгрөгийн тэтгэвэр илүү олгосон зөрчил илэрч, нөхөн төлүүлэхээр шийдвэрлэсэн. Мөн нийгмийн даатгалын ерөнхий газраас ирүүлсэн төлөвлөгөөт бус хяналт шалгалтын ажлыг удирдамжид заасан хугацаанд хийж гүйцэтгэн тайлан мэдээг тухай бүр хүргүүлэн ажиллаж байна. | | |
| 3.2.2. | Эрүүл мэнд, нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2017 оны 08 дугаар сарын 25-ны өдрийн А/129 дүгээр тушаалаар баталсан “Тэтгэвэр тогтоож, олгох үйлчилгээний заавар”-ын дагуу тэтгэвэр авагчдын тэтгэврийн хувийн хэрэг, | | Идэвхтэй, зогсоогдсон, нас барсан тэтгэвэр авагчийн тэтгэврийн хувийн хэргийн тооллогыг хагас, бүтэн жилээр хийж үр дүнг тооцох, | Илэрсэн зөрчил дутагдлыг арилгаж, тэтгэврийн хувийн хэргийн бүрдэл, эмх цэгц, хадгалалт, хамгаалалтыг сайжруулах, | Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2020 оны 12 дугаар сарын 30-ний өдрийн А/246 дугаар тушаалаар баталсан тэтгэврийн хувийн хэргийн тооллогын дэлгэрэнгүй бүртгэлийн нэгтгэл /ЗН-НД-6/, тэтгэвэр авагчдын хувийн хэргийн тооллогын нэгтгэл /ЗН-НД-7/ | Тус газар нь Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2020 оны 12 дугаар сарын 30-ний өдрийн А/246 дугаар тушаалаар баталсан тэтгэврийн хувийн хэргийн тооллогын маягтын дагуу нийгмийн даатгалын сангаас олгож байгаа тэтгэвэр авагчдын хувийн хэргийн тооллогыг Нийгмийн даатгалын газрын даргын тушаалаар ажлын хэсэг байгуулж, нийт 14094 тэтгэвэр авагчдын тэтгэврийн хувийн хэргийн бүрэн | 100 | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | хавсаргасан холбогдох үндсэн баримтын тооллогыг хагас, бүтэн жилд хийж, тэтгэвэр олгосон файл, жагсаалттай тулган шалгаж баталгаажуулах, | | | | маягтаар актыг 2 хувь үйлдэж, тухайн улирал, жилийн эцэст байвал зохих тэтгэвэр авагчийн тоог хувийн хэрэг, олгосон тэтгэврийн дүнтэй тулган баталгаажуулсан байна. | бүтэн байдал, хадгалалт хамгаалалтыг тэтгэврийн массайв болон нэгдсэн мэдээллийн баазтай тулган шалгахад байвал зохих хувийн хэрэг бүрэн тоологдсон. Тооллогын явцад тэтгэвэр авагчдын хувийн хэргийн хадгалалт хамгаалалт хангалтгүй, нэгдсэн мэдээллийн сангийн массайвын дараалын дагуу эмхэлж цэгцлээгүй хувийн хэргийн хавтас, хаяг, бүрдүүлэлтийг сайжруулах үүрэг өгч ажилласан. | | |
| 3.2.3. | Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллах. | | Зөрчлийн хэрэг бүртгэлийг явуулах, хяналт тавих, эрх бүхий албан тушаалтныг томилж тайлан мэдээг цаг хугацаанд нь гаргаж, Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, үр дүнг тооцох, | Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн хэрэгжилт хангагдсан байна. | Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн дагуу хариуцлага тооцож, шийтгэлийн хуудсаар төлүүлэхээр шийдвэрлэсэн торгуулийг 100 хувь, шимтгэл, алдангийг 70-аас доошгүй хувиар барагдуулсан байна. | 2024 оны байдлаар Зөрчлийн тухай хууль, Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн дагуу шийдвэрлэгдэх 1 байгууллагын гомдол мэдээлэл бүртгэгдсэн. Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 3.1, 4.8 дугаар зүйлүүдийг тус тус удирдлага болгон холбогдогчоос мэдүүлэг авч, хялбаршуулсан журмаар шийдвэрлэж, тухайн ажил олгогчийг Зөрчлийн тухай хуулийн 10.17 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу хоёр мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгон шийдвэрлэсэн.Торгуулийг бүрэн барагдуулсан. | 100 | |
| 3.2.4. | Дотоодын хяналт, шалгалтын хагас жилийн болон жилийн тайланг үнэн зөв гаргаж нийгмийн даатгалын сангийн гүйцэтгэлийн тайлантай тулган баталгаажуулах, Нийгмийн даатгалын ерөнхий газраас болон хөндлөнгийн хяналт, шалгалтаар илэрсэн төлбөр, зөрчлийн барагдуулалт, шалгалтын мөрөөр | | Дотоодын хяналт, шалгалтын хагас жилийн болон жилийн тайланг Нийгмийн даатгалын тухай хуулийн 13 дугаар зүйлийн дагуу, НДЕГ-с болон хөндлөнгийн хяналт, шалгалтаар илэрсэн | Дотоодын хяналт, шалгалтын хагас жилийн болон жилийн тайланг үнэн зөв гаргаж баталгаажуулах, шалгалтаар илэрсэн зөрчлийг арилгах, шалгалтын мөрөөр зохион байгуулж хэрэгжүүлсэн ажлын үр дүнг тооцож ажиллах, | Шалгалтын үр дүнг газрын даргын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлж холбогдох шийдвэр гаргуулан актаар тогтоогдсон төлбөрийн 70-аас доошгүй хувийг барагдуулсан байна. | 2024 оны жилийн эцсийн байдлаар шинээр 688 тэтгэвэр тогтоогдсон. Үүнээс өндөр насны 491, хөдөлмөрийн чадвар алдсаны тэтгэвэр 131, тэжээгчээ алдсаны 66 тэтгэвэр тогтоогдож хянагдсан байна. Мөн шилжиж ирсэн 20 тэтгэвэр, шилжиж явсан 82 тэтгэврийг баазад оруулж мэдээллийн баазын бүрдлийг ханган ажилласан байна. Шүүхийн шийдвэр болон улсын байцаагчийн актын дагуу суутгал хийгдэж байгаа 11 тэтгэврийг сар бүр суутгал хийн холбогдох дансанд шилжүүлж байна. Хөдөлмөрийн чадвар алдалтын хувь хугацаа сунгасан, жилийн нэмэгдэл | 80 | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | зохион байгуулж хэрэгжүүлсэн ажлын үр дүнг тооцож тайлан, мэдээг заасан хугацаанд Нийгмийн даатгалын ерөнхий газарт хүргүүлэх, | | төлбөр, зөрчлийн барагдуулалт, шалгалтын мөрөөр зохион байгуулж хэрэгжүүлсэн ажлын үр дүнг улирал тутамд гаргаж Хяналт, шалгалтын газарт ирүүлэх, | | | хийлгэсэн 510 тэтгэвэр авагчийн мэдээллийг хянан баталгаажуулсан. Тэтгэвэр авах эрхийн харилцаа дууссан нас барсан, зогсоогдсон 517 тэтгэвэр авагчийн олголтын тооцоог хийж хувийн хэргийг хянан архивд шилжүүлсэн байна.<br>НДЕГ-ын даргын 2024.05.29-ний 01/1107 албан бичгийн дагуу тэтгэвэр, тэтгэмжийн олголтыг шалган үзсэн. Шалгалтаар 14664 тэтгэвэр, тэтгэмж авагчийн олголтыг шалган үзэхэд 169 тэтгэвэр авагчид 39.9 сая төгрөгийг илүү олгосон зөрчил илэрч, 37.3 сая төгрөгийн төлбөр зөрчлийг арилгуулах ажлыг зохион байгуулан барагдуулсан.<br>Дотоодын хяналт шалгалтаар сайн дурын даатгалд хамрагдах гэрээ байгуулан сайн дурын даатгалын шимтгэл төлж байгаа 27 даатгуулагчийн өргөдлийн дагуу гомдол мэдээллийг шалгаж, залруулгын акт үйлдэн, мэдээллийн баазад засвар хийж зөрчлийг арилган ажилласан. Мөн 2022-2023 оны сайн дурын даатгалын хамралт, шимтгэл ногдуулалт, мэдээллийн баазын баяжилт, хуулийн хэрэгжилтийг шалгах дотоод хяналт шалгалтын төлөвлөгөөний дагуу 2022 онд Хэрлэн суманд хамрагдсан даатгуулагчдын мөнгө төлсөн баримт, харилцахын программ, гэрээтэй тулган шалгахад, алданги дутуу төлсөн болон төлөөгүй 48 даатгуулагчийн 0.7 сая төгрөгийг нөхөн төлүүлэх, ажил олгогчтой давхардсан болон алданги илүү төлсөн 7 даатгуулагчийн 0.4 сая төгрөгийг буцаан олгохоор ажилласан байна.<br>Тайлант хугацааны дотоодын хяналт, шалгалтын төлбөр зөрчлийн эхний үлдэгдэл 38.1 сая төгрөг байсан ба шинээр шалгаж илрүүлсэн 7.2 сая төгрөгийн төлбөр зөрчил нэмэгдэж, нийт 45.4 сая төгрөг болсон.Үүнээс 18.4 сая төгрөгийг барагдуулан | | |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | ажилласан байна. | | |
| ***Биелэлт – 670/7 95,7 %*** | | | | | | | | |
| ***Дөрөв. Төрийн үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулах зорилт.*** | | | | | | | | |
| *“Төрийн захиргааны удирдлагын манлайллыг хангах, бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн эрх зүйн үндэслэлийг судалж, хэрэгжилтийг хангах, төлөвлөх, тайлагнах, хүний нөөцийн бодлого, төлөвлөлтийг оновчтой зохион байгуулах, нийгмийн даатгалын үйлчилгээг хөгжүүлэх замаар байгууллагын тогтвортой хөгжлийг хангах”* ***гэсэн байгууллагын стратегийн зорилтыг хангахад чиглэсэн хөтөлбөр, арга хэмжээ:*** | | | | | | | | |
| 4.1.1. | Нийгмийн даатгалын салбарын хэрэгжүүлж буй үйл ажиллагаатай холбоотой гарсан тогтоол, тушаал шийдвэр болон гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээ, ажил үйлчилгээний хэрэгжилт, тайлан, дээд байгууллагаас өгсөн үүрэг даалгаврын биелэлтийг хугацаанд нь хүргүүлэх. | | Өгсөн үүрэг даалгаврыг цаг хугацаанд нь чанартай биелүүлсэн эсэх | Тайлан, биелэлтийг Нийгмийн даатгалын ерөнхий газарт хугацаанд нь хүргүүлсэн байх | Монгол Улсын хууль, Улсын Их Хурлын тогтоол, зөвлөмж, Засгийн газрын тогтоол, шийдвэрийн хэрэгжилт хангагдсан байна. | Нийгмийн даатгалын ерөнхий газраас хэрэгжүүлж буй үйл ажиллагаатай холбоотой Засгийн газрын тогтоол 14, Монгол улсын хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын тушаал 15, Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн тогтоол 3, Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын тушаал 23, нийт 55 бичгийг хүлээн авснаас хууль тогтоомжийн дагуу 51 албан бичигт хариу хүргүүлэн ажилласан. Мөн дээд байгууллагаас өгсөн үүрэг даалгаврыг цаг хугацаанд нь хүргүүлж, чанартай биелүүлсэн байна. | 100 | |
| 4.1.2 | ААНБ, иргэд, даатгуулагчдаас ирүүлсэн санал, өргөдөл гомдлыг хуулийн хугацаанд шийдвэрлэх ажлыг зохион байгуулах, үр дүнг хуулийн хугацаанд тайлагнах. | | Өргөдөл гомдлыг хуулийн хугацаанд шуурхай шийдвэрлэх ажлыг зохион байгуулах, үр дүнг хуулийн хугацаанд тайлагнасан эсэх | Иргэд, байгууллагаас ирсэн санал, өргөдөл, гомдлыг богино хугацаанд шийдвэрлэх. | Засгийн газрын “Иргэд олон нийттэй харилцах төв”-д болон иргэд, даатгуулагч, ААНБ-аас ирсэн өргөдөл, гомдлыг хуулийн хугацаанд бүрэн барагдуулж, тэдний тавьсан санал хүсэлтийг үйл ажиллагаандаа тусгаж ажиллах. | Нийгмийн даатгалын байгууллага нь иргэн, даатгуулагч, аж ахуй нэгж байгууллагаас ирсэн санал, өргөдөл гомдлыг бүртгэж холбогдох ажилтан, албан хаагчдад хүлээлгэн өгч хуулийн хугацаанд нь шийдвэрлэхэд хяналт тавин ажилладаг. Тайлант хугацаанд нийт 165 өргөдөл, гомдол ирснээс 160 өргөдөл гомдлыг шийдвэрлэсэн.Үүнээс 5 өргөдөл гомдол хяналтын шатанд хүлээгдэж байна.<br>Мөн орон нутгийн 31-11 “ Иргэд олон нийттэй харилцах төв”-д 3 өргөдөл гомдол ирснийг тухай бүрд хариуг өгч мэдээлэн ажилласан. | 100 | |
